




МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

ЗАМ, ТЭЭВРИЙН
ХӨГЖЛИЙН ЯАМ



ДАЛАЙН ЗАХИРГААНЫ 2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ
2019 он

1

Монгол Улсын далайн тээврийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр:

- ОУДБ-ын аудитын шалгалтын зөвлөмжийн хэрэгжилтийн тайлан.
- Монгол Улсын нэгдэн орсон далайн салбарын гэрээ, конвенцыг хэрэгжүүлэх төлөвлөгөө” 2018-2021 он /Засгийн газрын 2018 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 201 дүгээр тогтоол/
- Далай ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл.
- “Далбааны эзэн улсын хяналт шалгалтыг хэрэгжүүлэх хяналтын байцаагчийн ажлын хувцас, үнэмлэх, тэмдэгний загвар, техник хэрэгсэл, тэдгээрийг хэрэглэх дүрэм”, “Далбааны улсын хяналтын байцаагчийн үзлэг шалгалт явуулах журам”.
- “Хөлөг онгоц бүртгэх журам”-ын төсөл.
- Олон улсын Хөдөлмөрийн байгууллагын “Далайн хөдөлмөрийн тухай” 2006 оны конвенцын 2014 оны нэмэлт өөрчлөлтөд Монгол Улс нэгдэн орох бэлтгэл ажил.
- ОУДБ-ын “Далайчныг сургах стандарт, гэрчилгээ олгох болон ээлжийн ажиллагааны тухай” 1978 оны конвенцын 2010 оны нэмэлт, өөрчлөлт.

2


Хөлөг онгоцны бүртгэл, хяналтын чиглэлээр:

*2018.12.15-ны байдлаар

203 хөлөг онгоцыг шинээр бүртгэж

380 хөлөг онгоц идэвхтэй бүртгэлд байна.

- 364 Энгийн бүртгэлтэй
- 13 Нэг удаагийн аяллын бүртгэлтэй
- 3 Хөлөг онгоц дангаар түрээслэх бүртгэлтэй



2

Хөлөг онгоцны бүртгэл, хяналтын чиглэлээр:

Хүлээн зөвшөөрөгдсөн 16 байгууллагатай хамтран ажиллаж байна.



SingClass International (SCI)



Lloyd's Register (LR)



Turkish Lloyd (TL)



PT Biro Klasifikasi Indonesia (BKI)



Korean Register of Shipping (KRS)



Indian Register of Shipping (IRS)



International Marine Survey Association (IMSA)



Russian Maritime Register of Shipping (RMRS)



VietNam Register (VR)



Sing Lloyd (SGL)



International Register of Shipping (IS)



Foresight Ship Classification (FSCLASS)



China Corporation Register of Shipping (CCRS)



International Naval Surveys Bureau (INSB)



Hellenic Register of Shipping (HRS)



Aegean Register of Shipping (CLASSARS)

2

Хөлөг онгоцны бүртгэл, хяналтын чиглэлээр:

Далбааны эзэн улсын хянан шалгагчийг мэргэшүүлэх ажлын хүрээнд:



БНХАУ-ын Нингбо хотод ОУДБ-аас 2018 оны 07 дугаар сарын 23-27-ны өдрүүдэд зохион байгуулсан “Далайн тээвэр болон боомтын аюулгүй ажиллагааны бүс нутгийн сургалт”-ад далбааны эзэн улсын хяналтын 2 байцаагчийг хамруулав.



ОУДБ-аас 2018 оны 11 дүгээр сарын 05-09-ний өдрүүдэд Сингапур улсад зохион байгуулсан “Аюулгүйн ажиллагааны олон улсын менежментийг хэрэгжүүлэх талаарх бүс нутгийн хэмжээний сургалт”-д далбааны эзэн улсын хяналтын байцаагчийг хамруулав.

2

Хөлөг онгоцны бүртгэл, хяналтын чиглэлээр:

Далбааны эзэн улсын хяналт шалгалт:

2018 онд Монгол Улсын далбаатай нийт 67 хөлөг онгоц 110 удаагийн үзлэг шалгалтанд хамрагдсан байна.




Хөлөг онгоцны нэр	MORAY	DRAGON	NAUTICAL 7
IMO* дугаар	9123879	9075412	8817760
Бохир/цэвэр даац	7463/4680	7354/3067	1997/1216
Үйлдвэрлэгдсэн он	1996	1994	1988
ХЗБ**	Сингкласс	Сингкласс	Сингкласс



2

Хөлөг онгоцны бүртгэл, хяналтын чиглэлээр:

Хөлөг онгоцыг алсын зайнаас хянах систем:




3

Далайн тээвэр, боомт ашиглалтын чиглэлээр:



БНСУ-ын “Саммок Шиппинг” ХХК-ийн төлөөлөгчидтэй уулзах үеэр “Монгол-Саммок Ложистикс” ХХК-ийн үйл ажиллагааг ойрын хугацаанд эхлүүлэх талаар хамтарсан судалгааны ажлын хэсэг гарган ажиллах нь үр дүнтэй гэдэг дээр талууд санал нэгдсэн. /2018 оны 11 дүгээр сар/

Далайн тээвэр, боомт ашиглалтын чиглэлээр:



Тайлбар: Монгол Улсын уул уурхайн бүтээгдэхүүнийг ОХУ-ын Восточный далайн боомтоор дамжуулан далайгаар тээвэрлэн гуравдагч орнуудад хүргэх маршрутын зураглал.

2018 онд хийсэн судалгаа:

- “Монгол Улсын уул уурхайн бүтээгдэхүүнийг ОХУ-ын “Восточный” далайн боомтоор дамжуулан гуравдагч орны зах зээлд тээвэрлэн хүргэх нөхцөл боломж”;
- “Монгол Улс Оросын Холбооны Улсын Алс Дорнодын боомтоор нүүрс дамжуулан тээвэрлэхэд хөрөнгө оруулж хамтран ажиллах нөхцөл боломж” (Вера боомт, Восточный боомт, Ванино боомт);
- “Монгол Улсын бараа, бүтээгдэхүүнийг БНХАУ-ын “Жинжоу” далайн боомтоор дамжуулан тээвэрлэх нөхцөл боломж, зардлын тооцоолол”;
- “Монгол Улсын экспорт, импортын бараа бүтээгдэхүүнийг Итали Улсын Генуя далайн боомтоор дамжуулан тээвэрлэх эдийн засгийн тооцоо судалгаа”;

3

Далайн тээвэр, боомт ашиглалтын чиглэлийн хамтын ажиллагаа:

Монголын тээвэр зуучлагчдын нэгдсэн холбоотой хамтран ажиллах санамж бичиг 2018.06.15



Уг санамж бичгийн хүрээнд БНХАУ-ын Эрээн хотноо хоёр талын холбооны хамтарсан зөвлөгөөн зохион байгуулав.

Далайн захиргаанаас “НҮБ-ын далайн эрх зүйн тухай конвенц ба Монгол Улсын эрх” сэдвээр илтгэл тавьж оролцов.

Зөвлөгөөнөөр хэлэлцсэн асуудал:

“БНХАУ-ын нутгаар дамжин өнгөрч буй импортын бараа, бүтээгдэхүүний тээвэрлэлттэй холбоотой хүндрэл бэрхшээл”



3

Далайн тээвэр, боомт ашиглалтын чиглэлийн хамтын ажиллагаа:



Далайн захиргаанаас НҮБ-ын ДГХБО-ын Олон Улсын Судалгааны төвтэй хамтран “Худалдааг хөнгөвчлөх санаачлага болон тээвэр логистикийн салбарт тулгамдаж буй асуудлууд” сэдэвт семинар, хэлэлцүүлэг. /2018.11.29/

Семинар, хэлэлцүүлэгт:

Монгол Улсын Гадаад харилцааны яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Эрдэнэс Тавантолгой ХК, Шарын гол ХК, Үндэсний хөгжлийн газар, Гаалийн ерөнхий газар, Монголын тээвэр зуучлагчдын нэгдсэн холбоо болон тээвэр логистикийн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, эрдэмтэн судлаачид зэрэг 80 гаруй төлөөлөл оролцсон.




3

Далайн тээвэр, боомт ашиглалтын чиглэлээр:

ОЛОН УЛСЫН ДАЛАЙН БАЙГУУЛЛАГААС ЭМХЭТГЭН ГАРГАСАН ДАЛАЙН ХАРИЛЦААНЫ ҮГ ХЭЛЛЭГИЙН СТАНДАРТ		
АГУУЛГА		
ЗААЛТУУД		Хуудасны дугаар
ТАНИЛЦУУЛГА		5
1	Далайн харилцааны үг хэллэг (ДХҮХ)-ийн хэрэглээ	
2	Далайн харилцааны үг хэллэгийн стандартын бүтэц	
3	ДХҮХ-ийн бүтэц	
4	Харилцаа холбооны үндсэн хэв шинжүүд	
5	Хэвлэлийн тэмдэг, тэмдэглэгээний утга	
6		
ЕРӨНХИЙ ЗҮЙЛ		7
1	Ашиглах заавар	
2	Үгийг үсэг, үсгээр дуудах	
3	Мэдээллийн тэмдэглэгээ	
4	Асуултанд хариулах	
5	Хөлөг онгоц сүйрэх болсон нөхцлийн түгшүүрийн болон аюулгүй ажиллагааны дохио тэмдэглэгээ	
6	Зохион байгуулалтыг хийх стандарт үг хэллэг	
7	Залруулга хийх	
8	Бэлэн байдал	
9	Давтаж хэлэх	
10	Тоо болон дугаарлалтыг дуудах	
11	Байршлын мэдээллийг дамжуулах	
12	Байршлын тэмдэглэгээ	
13	Хөлөг онгоцны чиглэл	
14	Зайн илэрхийлэл	
15	Хурд	
16	Цаг хугацаа	
17	Газарзүйн байршлын нэр томъёог дуудах	
18	Хоёрдмол утгатай үгсийн хэрэглээ	
ТАЙЛБАР ТОЛЬ		14
1	Ерөнхий үг хэллэг /general terms	
2	VTS тусгай хэллэгүүд	
ДАЛАЙН САЛБАРЫН СТАНДАРТ ХЭЛЛЭГҮҮД ХЭСЭГ А		26
AI	Дотоод харилцаа холбооны хэллэг	26
AI/1	Осол аваарын үеийн харилцаа холбоо	26
AI/1.1	Осол аваарын үеийн тээврийн урсгал	26

Олон Улсын Далайн Байгууллагаас эмхэтгэн гаргасан “Далайн тээврийн харилцаа, холбоонд ашиглагддаг стандарт үг, хэллэг”-ийн тайлбар толь бичгийг англи хэлнээс орчуулан толь бичиг хэлбэрээр эмхэтгэн боловсруулав. (Standard Maritime Communication Phrases of IMO)



4

Усан замын тээврийн бүртгэл, хяналтын чиглэлээр:

“Усан замын тээврийн тухай” хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд холбогдох дүрэм, журмын төслийг шинээр болон шинэчлэн боловсруулах

- Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх, тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам /Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 119 дүгээр тушаалаар батлагдсан/
- Усан замын тээврийн хэрэгсэлд, объектын техник ашиглалтын дүрэм /Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 277 дугаар тушаалаар батлагдсан/
- Усан замын тээврийн хэрэгслийн жолооч, мэргэшсэн жолооч бэлтгэх, сургалтын хөтөлбөр батлах журам /Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 252 дугаар тушаалаар Ажлын хэсэг байгуулсан/
- Усан замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объектод гэрчилгээ олгох журам / Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 277 дугаар тушаалаар батлагдсан/

4

Усан замын тээврийн бүртгэл, хяналтын чиглэлээр:

Усан замын тээврийн хэрэгслийн бүртгэл тооллогын “Нэг цэгийн үйлчилгээний төв”-ийг Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд байгуулах бэлтгэл ажлыг хангаж ажилласан.



- Усан замын тээврийн хэрэгслийг улсын бүртгэлд бүртгүүлэх,
- Усан замын тээврийн хэрэгслийн бүртгэлд шилжилт хөдөлгөөн хийх,
- Техникийн хяналтын үзлэг хийх,
- Иргэдийг мэдээллээр хангах,

“Нэг цэгийн үйлчилгээний төв”-өөр давхардсан тоогоор нийт 60 гаруй иргэн үйлчлүүлсэн байна. Мөн бүртгэлд шилжилт хөдөлгөөн хийлгэх тухай аж ахуйн нэгж, иргэний 27 хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн.

4

Усан замын тээврийн бүртгэл, хяналтын чиглэлээр:

Усан замын тээврийн техникийн хяналтын үзлэг

“Усан замын тээврийн тухай” хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-т заасны дагуу жил бүр техникийн хяналтын үзлэг, тооллогыг зохион байгуулан ажиллаж байна

2018 оны техникийн хяналтын үзлэгт хамрагдсан усан замын тээврийн хэрэгслийн тоо:



Аймаг, орон нутгийн нэр	Хөвсгөл	Архангай	Увс	Ховд	Баян-Өлгий	Булган	Сэлэнгэ	Дорнод	Нийслэл	Нийт
Усан замын тээврийн хэрэгслийн тоо	98	12	3	1	2	4	3	4	2	129
Техникийн үзлэгт тэнцсэн	74	5	1	1	-	3	-	-	1	85
Техникийн үзлэгт тэнцээгүй	6	7	1	-	-	-	-	4	1	19
Засвартай болон бусад шалтгаанаар үзлэгт хамрагдаагүй	18	-	1	-	2	1	3	-	-	25

- Усан замын тээврийн хэрэгсэл шинээр улсын бүртгэлд бүртгэсэн - 17
- Усан замын тээврийн хэрэгсэлд шилжилт хөдөлгөөн хийсэн - 7
- Бүртгэлээс хасч, гэрчилгээг хүчингүй болгосон - 7

Усан замын тээврийн бүртгэл, хяналтын чиглэлээр:

“Усан замын тээврийн аюулгүй ажиллагаа” сэдэвт хамтарсан сургалт, семинар



Хөвсгөл аймгийн Хатгал тосгон, /2018.06.12/

Оролцогч байгууллагууд:

- Зам, тээврийн хөгжлийн яам
- Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
- Хөвсгөл аймгийн ЗДТГ
- Хөвсгөлийн Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа
- Хөвсгөл нуур-Эгийн голын сав газрын захиргаа
- Хөвсгөл аймгийн Онцгой байдлын газар
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв
- Даатгалын компаниуд

Орон нутгийн байгаль хамгаалагчид болон усан замын тээврийн үйлчилгээ эрхлэгч иргэд, аж ахуйн нэгж, байгууллагууд, завь жолоодогч зэрэг 100 гаруй хүн оролцсон.

4

Усан замын тээврийн бүртгэл, хяналтын чиглэлээр:

ХБНГУ-ын Далайн эрэн хайх, авран туслах байгууллагаас буцалтгүй тусламжаар өгсөн аврах 2 завийг оруулж ирэх ажлыг зохион байгуулах

“Аврах завь тээвэрлэх ажил”-ыг гүйцэтгэх компанийн сонгон шалгаруулалтыг явуулав.
/2018.07.09/

Сонгон шалгаруулалтад шалгарсан “Нью сентюри ложистик” ХХК Аврах 2 завийг ХБНГУ-аас Хөвсгөл аймгийн Хатгал тосгон хүртэл тээвэрлэв.

Далайн захиргаанаас томилогдсон Ажлын хэсэг аврах завинуудыг Хатгал тосгонд хүлээн авав.
/2018.11.22/



4

Усан замын тээврийн бүртгэл, хяналтын чиглэлээр:

Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд “Завины өвлийн битүү зогсоолын барилга барих, гадна тохижилтын ажил”

Аврах завины өвлийн битүү зогсоол барих ажлын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалт /2018.08.06/

Гүйцэтгэгч: БУЗТ ХХК

Өндөржилт, гадна тохижилт

Гадна цахилгаан, гэрэлтүүлэг, 63 кВт хүчин чадалтай иж бүрэн дэд өртөө


Ариун цэврийн байгууламжийн барилга (цэвэр усны хангамж, бохир усны цооног)

Хүлээж авах хугацаа: 2019.05.15



5

Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр:



БНХАУ-ын Далайн аюулгүй байдлын захиргаатай далайн салбарт хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын Санамж бичиг /2018.01.29, Бээжин хот/

5

Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр:



Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Далайн захиргаатай хамтран ажиллах тухай Харилцан ойлголцлын Санамж бичиг /2018.08.08, Ханой хот/



Хамтран ажиллах чиглэл:

- Хөлөг онгоцны бүртгэл
- Далайн тээвэр, боомт ашиглалт
- Боловсон хүчин бэлтгэх

5

Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр:



Бүгд Найрамдах Чили Улсын Вина Дел Мар хотноо 2018 оны 04 дүгээр сарын 10-12-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Ази, Номхон далайн бүс нутгийн далайн тээврийн аюулгүй байдлын агентлагуудын удирдлагуудын 19 дэх удаагийн зөвлөгөөний үеэр Монгол Улсын Далайн захиргаа тус байгууллагад гишүүнээр элссэн.



БНСУ-ын Бусаны боомтын захиргаанаас зохион байгуулсан Боомтын олон улсын VI бага хуралд “Монгол-Орос-Хятадын Эдийн засгийн коридор хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын Далайн салбарт хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа” сэдэвт илтгэл тавьж оролцов.

Далайн тээврийн салбарт ажиллах боловсон хүчин бэлтгэх чиглэлээр:



ОХУ-ын Адмирал Г.И.Невельскойн нэрэмжит Тэнгисийн их сургуультай Хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичиг /2018.09.12, Владивосток хот/



БНСУ-ын Далай, загас агнуурын технологийн институтийн удирдлагатай 2019 онд суралцах оюутнуудыг сонгон шалгаруулах талаар санал солилцох уулзалт /2018.11.05, Бусан хот/

Анхаарал хандуулсанд баярлалаа



ДАЛАЙН ЗАХИРГАА

Утас: +976-11 261489
+976-11 261490

Факс: +976-11 310642

И-мэйл: info@monmarad.gov.mn
registry@monmarad.gov.mn

Цахим хуудас: www.monmarad.gov.mn